



**НОМГОН СУМ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2019 ОНЫ АЖЛЫН
ТАЙЛАН**

2019 ОН

НОМГОН СУМЫН ИТХ-ЫН ИРГЭНИЙ ТАНХИМЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.12.11.

Номгон сум

Сумын ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажиллаа.




НЭГ. ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ УУЛЗАЛТ,
ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН ТАЛААР:

- Номгон сумын "Тэмээний баяр" , Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн жилийн нээлтийн арга хэмжээ, багуудын нэгдсэн өдөрлөгийг 2019.01.15,16-ний өдрүүдэд зохион байгуулж малчид иргэдэд ИТХ-ын дарга Н.Буянхишиг сум орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт, ажил арга хэмжээний талаар мэдээлэл хийж Байгальд ээлтэй ноолуур төсөл, Байгаль зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэгтэй хамтран байгальд ээлтэй ноолуур төслийн талаар, Номгон суманд бэлчээрийн менежментийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлын талаар, малчид хөдөлмөрөө хоршиж ажиллах нь ямар ашигтай вэ зэрэг чиглэлээр сургалт мэдээллийг өгч, мал аж ахуй, үйлдвэржилтийн цаашдын зорилтын талаар хэлэлцүүлэг хийж нийт 120 гаруй хүнийг хамруулж саналыг

- Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгчидтэй уулзаж саналыг хүлээн авч "Дархан бэр" хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан Номгон сумын "Дархан бэр" энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох журам боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр болж тус журмын төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2019.02.27-ний өдөр ИТХ-ын Ажлын албанаас зохион байгуулж нийт 18 хүнийг хамрууллаа. Үүнд Төрийн болон төрийн бус

байгууллагын төлөөлөл болох ЗДТГ-ын дарга, мэргэжилтэн, багийн Засаг дарга нар, ИТНХ-ын дарга, Ахмадын хорооны тэргүүлэгч, Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчид оролцууллаа.



- Сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжин ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөрийг боловсруулан гаргаж, ахмадуудыг сумын бүтээн байгуулалттай танилцуулан тэдний санал бодлыг сонсох уулзалтын арга хэмжээг зохион байгуулж нийт 100 гаруй хүнийг хамруулсан.



ХОЁР. СУРГАЛТ ХИЙСЭН ТАЛААР:

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын зөвлөгөөнийг 2019.04.04-ний өдөр зохион байгуулж төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар байгууллагуудын илтгэл, мэдээллийг сонсон, төрийн албан хаагчдад зориулсан сургалт мэдээллийг хийж нийт 40 гаруй төрийн албан



хаагчдыг хамрууллаа. ИТХ-ын Ажлын албанаас Төрийн



албаны тухай хуулийн ерөнхий ойлголт, төрийн албаны шатлан дэвших зарчмын тухай сургалт хийсэн.

Сумын ИТХ-аас Өмнөговь аймгийн Насан туршийн боловсролын төвийн багшийг урьж ирүүлэн сургалтын төлбаригг хариуцан төрийн албан хаагчдын ёс зүй, төрийн албан хаагчдын харилцаа,

хандлага сэдвээр сургалт хийлээ.



- УЗАШХ-нд бүртгэлтэй гишүүд, ивээн тэтгэгч, онцгой гишүүдээ алдаршуулах, сумын анхан шатны хорооны үйл ажиллагааг идэвхижүүлэхэд оруулж буй тэдний хувь нэмрийг нийтэд таниулах, онцгой гишүүдийнхээ эгнээг өргөжүүлэх

зорилгоор .аймгийн УЗДШХороотой хамтран "МУЗН-ийн гишүүдийн оролцоо" арга хэмжээг 2019.03.03-ний өдөр зохион байгуулж нийт 40 гаруй гишүүд, дэмжигчдийг хамруулж МУЗН-ийн гишүүнчлэл, үйл ажиллагааны талаар сургалт мэдээлэл хийж, гишүүн шинээр элсүүлэн, гарын авлага материал түгээж ажиллаа.

Залуучуудад
боловсрол
олгох
зорилгоор
Номгон
суманд
зохион



байгуулагдсан цэргийн бүртгэлийн арга хэмжээний үеэр сумын ИТХ, ГХУСАЗСЗ-өөс цэргийн насны залуучуудад зориулан гэмт хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, архи согтууруулах ундааны хор уршиг, санхүүгийн боловсрол олгох чиглэлээр хуримтлалыг хэрхэн бий болгох вэ, түүний ашиг тус сэдвээр сургалтыг зохион байгуулж нийт 40 гаруй цэргийн насны залуучуудыг хамруулсан.



- Хүүхдээ сонсоё чуулганаар сумын ИТХ-аас Өмнөговь аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэнг урьж ирүүлэн "Манлайлалт" сургалтыг хийж, хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, гаргасан санал, хүсэлтийг нэгтгэн тус чуулганаас цаашид дараахь ажил, арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

- Сумын хэмжээнд хүүхдийн спортын наадмыг зохион байгуулах

- "Хүүхэд хэрэглэгч" боловсрол олгох сургалтыг зохион байгуулах



- ЕБС-ийн авъяаслаг, бүтээлч багш чадвар, нөөц боломжид тулгуурлан хүүхдийн сонирхол, авъяасыг хөгжүүлэх чиглэлээр дугуйлан хичээллүүлэх, дугуйлангийн тоог нэмэгдүүлэх
- Спортын мастер Ц.Баярмаагийн "Гар бөмбөг"-ийн секц хичээллүүлэх
- Сумын төвийн гудамж, олон нийтийн газар хогийн сав байрлуулах
- Худалдаа үйлчилгээний газарт хяналт тавих ажлыг тогмолжуулах
- Золбин нохой устгах ажлыг жилд 2 удаа зохион байгуулах
- Хүүхдийг шүдний эмчийн үзлэгт жилд 2-3 удаа хамруулах
- Гитар хөгжмийн дугуйланд гитар хөгжмийн тоог нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг 2020 онд хэрэгжүүлэхээр хүүхдийн чуулганаас саналыг гаргаж баталлаа.

- Сумын ИТХ-аас Татварын Улсын байцаагч Х.Мөнхбаттай хамтран "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хууль, "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" / ААНОАТТ/ хуулийн сургалтыг хийж нийт ААН, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 14 хүнийг хамрууллаа.



- Багийн нэгдсэн өдөрлөгийн үеэр зохион байгуулагдсан мэдээллийн цагаар Малчид иргэдэд зориулан Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг буруулах нь сэдвээр сургалт хийж 60 гаруй хүнийг хамруулсан.

ГУРАВ. СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТАЛААР:

- Сумын ИТХ болон дээд шатны хурлын шийдвэр, ЗДТГ, бусад байгууллага, албан газраас орон нутагт зохион байгуулагдсан ажил арга хэмжээ, нийтэд хүргэх мэдээлэл, зар мэдээллийг Номгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын face book, хурал.мн цахим хуудсаар тогтмол мэдээлж ирсэн.


- Мөн Номгончуудын амжилт мэдээллийг цаг тухай бүр олон нийтэд сурталчлан иргэйн гаргасан амжилт, гавъяа шагнал, иргэдийн оролцоо, үр дүнг цахимаар сурталчлан ажиллаж ирсэн.


The screenshot shows a Facebook page for the 'Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал' (Citizens' Representative Khural). The page header includes the name, a search bar, and navigation options like 'Home', 'Create', and 'Manage Posts'. The main content is a document titled 'ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ' (Resolution of the Citizens' Representative Khural of Omnogovi Aymag). The document text is as follows:

Өрх, гэр бүлийн хөгжлийн жил
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн хэмжээнд 2020 оныг "Өрх, гэр бүлийн хөгжлийн жил" болгон зарласгай.
2. "Өрх, гэр бүлийн хөгжлийн жил"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц үр дүнг хагас, бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиглахыг аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д үүрэг болгоосгай.

ХУРЛЫН ДАРГА  СҮГИР

Өмнөговь
December 9, 2019 ·  Like Page

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 198 дугаар тогтоолоор 2020 оныг "Өрх, гэр бүлийн хөгжлийн жил" болгон зарлаж онцлох томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

The page also features a 'Friends' section with 4,657 friends and a 'CONTACTS' list on the right side, including names like Bulгаа Bulgamaa, Sodbileg Batbayr, Buynhishig Buya, Tsэндoo Ganbaatar, Tsааganhuu Bayрмаа, Idersuren Sugir, Х. Бат-Эрдэнэ, Б. Адъяабат, Ууганчулуун Б.ТХ, and Бичигт Свoгт Өлзий.

Иргэдийн Төлөөлөгчдийн ... Timeline 2019 December Manage Posts List View Grid View

Lives in Nomgon, Omnogovi, Mongolia

Edit Details



Edit Featured

Photos Add Photo



Бямбацэрэн Нансалмаа Zaluuchuuddaa amjilt husie
Like · Reply · 4w

Write a comment...

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
December 11, 2019 ·

Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэж 83 хувьтай хэрэгжсэн гэж хуралд оролцсон төлөөлөгчдийн 56% - ийн саналаар дүгнэлээ.
Сумын ИТХ



Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувь

Хэлэлцүүлэг 3 удаа

Сургалт 5 удаа 12 сэдэв

ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА

Н.БУЯНХИШИГ

ТАЙЛАН БИЧСЭН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БУЛГАМАА

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчид нь Монгол Улсын Үндсэн хууль, ЗЗНДНТУТ хууль, дээд шатны байгууллагын бодлого шийдвэр, хууль тогтоомжийг удирдлага болгон сум орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, төрийн үйлчилгээг ил тод түргэн шуурхай байлгахад хяналт тавин ажиллаж байна.

ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн Тэргүүлэгчдийн хурлаар 5 бүлэг, 77 заалттайгаар батлан хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

НЭГ. ХУРАЛДААН

ИТХ-ын ээлжит наймдугаар хуралдааныг 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хуралдуулж доорх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

✓ Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэн 74,3 хувь буюу хангалттай гэж дүгнэсэн.

✓ Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлийн хагас жилийн хэрэгжилтийг хэлэлцэн 53,2 хувь буюу хангалттай гэж дүгнэсэн.

✓ Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцэн холбогдох газарт хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019.10.22-ний өдрийн 4485 дугаарт бүртгүүлсэн.

✓ Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийг сумын ИТХ-ын тэргүүлэгч Р.Одхүүгээр ахлуулан баг тус бүрээс иргэний төлөөллийг оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

✓ Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг Засаг даргаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.



✓ Орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт хийсэн дүнгийн тухай хэлэлцээд төрийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж хяналт тавьж ажиллахыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөл болон албан байгууллагын дарга нарт үүрэг болгож тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргад үүрэг болгосон.

✓ Зарим газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай хэлэлцээд Номгон сумын нутагт орших Булган уул орчмын 117,476,40 га, Их цохио баруун үзүүр 49,682,65 га, Баянгийн тал нэртэй 44,398,04 га, Их бага Номгон уулын ар хэсгээс Буурын хэц хүртэлх 131,990,33 га, Гэдрэгийн хэц, Эмгэнбулаг хүртэлх 112,547,52 га газруудыг байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалан хамгаалах зорилгоор ой, ховор ан амьтан, ус, ургамал байгалийн нөөц газраар 15 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар шийдвэрийг холбогдох газарт уламжлан бүртгүүлсэн.

✓ Засаг даргыг томилуулах асуудлыг хэлэлцэн сумын Засаг даргаар Ж.Баяр-Эрдэнэ ажиллаж байна

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдуулсан. Ирц 76,19 хувьтай, 10 асуудал хэлэлцэж 9 тогтоол гаргасан. Тус хуралдаанаар Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлах, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны үндсэн чиглэл батлах, 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах, 2020 оны төсөв батлах, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах, 2020 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил, зориулалтыг батлах, ан агнуурын бүс тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэн баталсан. Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 83, 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 88,4 хувь буюу хангалттай хэрэгжсэн гэж дүгнэлээ.



Сумын нийт төсөв 2020 онд



2,536,987,5, орон нутгийн хөгжлийн сангаар нийт 15 ажил арга хэмжээнд 397977,7 төгрөгийн төсвөөр Эрүүл мэндийн төвийн цэвэр, бохир, дулаан, цахилгааны засвар, цэвэр, бохирт холбох, Бялдаржуулах танхимтай болох, Наадмын талбайн

зураг, сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, ЕБС-ийн гал тогооны тоног төхөөрөмж, ЗДТГ-ын засвар зэрэг ажил арга хэмжээг хийхээр баталсан. Мөн сум хөгжүүлэх санд 54000,0 төгрөгийг тус тус баталсан.

ХОЁР. ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ

2019 онд Тэргүүлэгчид 12 удаа хуралдаж 27 асуудал хэлэлцэн 32 тогтоол батлан хэрэгжүүлж байна.

Хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрүүд:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх тухай.
2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай.



3. Төрийн шагналд тодорхойлох тухай.
4. Алдарт эхийн одонд тодорхойлох тухай.

5. Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн саналыг дэмжих тухай.
 6. Номгон сумын Дархан бэр энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох журам батлах тухай.
 7. ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимын 2019 оны төлөвлөгөө батлах тухай.
 8. ИТХ-ын дэргэдэх Хороодын 2019 оны ажлын төлөвлөгөө батлах тухай.
 9. Агнуурын бүс нутаг тогтоох тухай.
 10. Агнуурын бүс нутгийн агнуурын менежментийн төлөвлөгөө батлах тухай.
 11. Орон нутгийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын тайлан хэлэлцэх.
 12. Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх тухай.
 13. Сумын баяр наадмын тов зарлах тухай.
 14. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны тайлан сонсох тухай.
 15. Хүслийн цагаан овоо тахих тухай.
 16. ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах
 17. Соёлыг дэмжих ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай
 18. Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт
 19. Хөрөнгө актлах тухай
 20. Хуралдааны тов зарлах тухай
 21. Хэлэлцэх асуудал илтгэгчийг батлах тухай
 22. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов зарлах тухай
 23. Засаг даргын орлогчийг зөвшилцөх тухай
 24. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх тухай
- Тэргүүлэгчдийн хурлын дундаж ирц 83,33 хувьтай.

Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийг холбогдох газарт хүргүүлэн мэдээллийн самбар болон сумын ИТХ, хурал.мн зэрэг цахим хуудсаар танилцуулан сурталчилан ажиллаж байна.

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДЛЫН ХҮРЭЭНД:

Бодлогын чанартай асуудлаар: Сумын ИТХ, тэргүүлэгчдээс хийх ажлын төлөвлөгөө, Хороодын ажлын төлөвлөгөө, Иргэний танхимын төлөвлөгөө зэргийг батлан хэрэгжүүлж ажиллаж байна. ИТХ, Тэргүүлэгчдийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай, Иргэний танхим 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 70 хувьтай хэрэгжсэн буюу нийт 2 удаа хэлэлцүүлэг хийж 62, 3 удаа уулзалт ярилцлага хийж 152, 6 удаа сургалт зохион байгуулж 308 хүнийг хамруулсан байна.

Байгууллага, Аж ахуйн нэгжийн ажтлын тайлан сонсох асуудлаар:

- Соёлыг дэмжих жилийн ажлын хэрэгжилтийг сонсон хэрэгжилтийг дүгнэн шинээр ашиглалтад орох соёл спортын цогцолборын дулаан хаалалтын төлбөр,

нээлтийн арга хэмжээ, соёлын өвийг хамгаалах гэрээт харуулуудад олгох урамшууллын асуудлыг судлан шийдвэрлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллаа.

- Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийг дэмжих жилийн ажлын хэрэгжилтийг сонсож дүгнэн иргэд малчдад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулах талаар чиглэл өгсөний үр дүнд Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийг дэмжих жилийн ажлаараа аймагт дэд байранд шалгарч 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх эрхээр шагнагдсан амжилттай байна.

Байгаль орчин, газрын асуудлаар:

- Сумын нутаг дэвсгэрт байрлах Хонгор, Өвөр сайр, Хөндий 2, Хөндий 3, Ар сайр, Найман, Отог, Хөндий 1, Баян бяруу, Номгон, Дэл, Хуурай сайр, Хөндий 4, нэртэй нийт 13 талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох саналыг дэмжин хяналт тавин ажиллаж байна.

- Номгон сумын Төхөм багийн Цохиот нутагт ан агнуурын бүс нутгийг тогтоон зураглал, хилийн цэс, менежментийн төлөвлөгөөг батлан сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байгаа. Буур, Номгоны агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг баталсан, 2019 онд 48,397 сая төгрөгийн орлого орж ирсэн.

Төсөв санхүү, өмч хөрөнгийн асуудлаар: Орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалатнд хяналт хийж сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэн ажлын хэсэг байгуулж, хяналт хийсэн дүнгийн тухай ИТХ-ын ээлжит хуралдаанд танилцуулсан. төсөвт албан байгууллагуудын өмч хөрөнгөд хяналт хийж, нийт 2 зөрчил илрүүлж, зөвлөмж чиг үүргийг өгч ажиллаа.

- Өмч хөрөнгө актлах тухай хэлдэлцэн Тамгын газрын хөрөнгө болох Ахмадыг өргөө,Төхөм багийн конторын барилга, Эрхэс гуа ОНӨААТҮГ-ын эмийн сангийн барилгыг хагас жилийн тооллогоор тус тус акталсан.

Иргэдийн шагналд тодорхойлох асуудлаар. Төрийн шагналд нийт 15, Алтан гадас одонд 6, Хөдөлмөрийн хүндэт медальд 8, Монгол Улсын гавъяат барилгачин шагналд 1 хүнийг тодорхойлон шагналын материалыг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох газарт хүргүүлэн ажилласан. Алдарт эхийн 2-р зэргийн одонгоор 9 ээж шагнагдсан. Мөн Номгон сумын “Дархан бэр” энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох журмыг батлан 2019 онд нийт 31 эхийг дархан бэр энгэрийн тэмдэгээр шагнаж хүндэтгэл үзүүлсэн.

Ажлын хэсэг, зөвлөлийн асуудлаар:

- Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажлын тайланг хэлэлцэн, зөвлөлийн үйл ажил ажиллагаанд хяналт хийж ажиллахыг нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороонд даалгаж, зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан, иргэдэд олгосон зээлт төсөл хөтөлбөрийг нээлттэй сурталчилан ажиллахыг чиглэл болгон ажиллаа

- Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай танилцаж үүрэг чиглэл өгч төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг Төлөөлөгчдийн хуралдаанд оруулан шийдвэрлүүлээ.

- **Иргэд, албан байгууллагаас гарсан санал, хүсэлтийн асуудлаар:** Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл, Монгол Улсын Аж үйлдвэрийн гавъяат ажилтан Ц.Даваацэрэнгийн санал хүсэлтийг хүлээн авч Дэрсэнэ-ус багийн нутаг дэвсгэрт орших Хүслийн цагаан уулыг 2019.06.24-ний өдөр тахиж ёслол үйлдэн 300 гаруй иргэдийг хамруулсан.

- Цэргийн дүйцүүлэх албах хаах хүсэлтэй 10 иргэний өргөдлийг хэлэлцэн 7 хүний өргөдлийг дэмжин шийдвэрийг аймгийн цэргийн штабт хүргүүлж, 2019 онд 8 хүн цэргийн дүйцүүлэх албыг хааж байна

ГУРАВ. БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ

2019 оны 01 дүгээр сарын 15-ний өдөр сумын төвд Хөдөө аж ахуй үйлдвэржилтийг дэмжих жилийн нээлтийн арга хэмжээ, багуудын нэгдсэн өдөрлөг хурлыг зохион байгуулж, энэ үеэр Хармагтай баг, Дэрсэнэ-ус багууд хуралдаж багийн Засаг даргын ажлын тайлан, Иргэдийн шагналд тодорхойлох, багийн туг,



лого батлах, иргэдийн өргөдөл хэлэлцэх, багийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах, Багийн ИНХ, Засаг даргаас хийх ажлын төлөвлөгөө батлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж хурлын материалыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлсэн байна.

Малчдын нэгдсэн хурлаар сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга нараас сум орон нутгийн цаг үеийн мэдээлэл өгч ИТХ-ын Ажлын албанаас МУЗН-ийн Анхан шатны хорооны 2018 оны ажлын тайланг танилцуулж, МУЗН-ийн үйл ажиллагаа, гишүүнчлэлийн талаар сургалт мэдээлэл хийлээ.

2019 оны 5 дугаар сард багуудын 2 дугаар улирлын ээлжит хурлуудыг зохион байгуулж Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний санал эрэмбэлэх, Газар эзэмших өргөдөл саналыг хэлэлцэх, малчдыг шагналад тодорхойлох, зарим газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, өвөлжөөний доорх газрыг эзэмшүүлэх, багийн 60 жилийн ойг тэмдэглэх тухай зэрэг асуудлыг хэлэлцэн багууд ИНХ-ын материалыг Хурлын ажлын албанд ирүүлсэн байна.



11 дүгээр сард багууд ИНХ-ын хуралдаанаа зохион байгуулж Номгон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлан сонсох, багийн ойн арга хэмжээний тайлан сонсох, өвөлжөөний доорх газар эзэмшүүлэх, иргэд, малчдыг шагналд тодорхойлох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Багийн хурал, араг хэмжээнд Хурлын дарга оролцож сум орон нутгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж иргэдийн саналыг сонсож ажиллаа.

Багийн ИНХ-ын дарга нарын урамшууллыг сар бүр тооцон олгож байна.

ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд сумын ИТХ-аас 5 багийн өдөрлөгийн үеэр Үндсэн хуулийн ач холбогдолын талаар мэдээлэл хийж 120 хүнийг хамрууллаа. Мөн төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид, иргэд залуучуудын дунд ИТХ-ын нэрэмжит цомын төлөөх Гар бөмбөгийн тэмцээнийг 2019.01.15-ний өдөр зохион байгуулж нийт 12 багийн 72 хүнийг хамрууллаа.

- Тэргүүлэгчдийн ажлын албанаас сумын ИТХ-ын төлөөлөгчдийн болон багийн Засаг дарга, улс төрийн албан тушаалтаны / нийт 27 хүн/ 2018 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг холбогдох газарт цаг хугацаанд нь хүргэлээ.

- Номгон сумын "Тэмээний баяр" , Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн жилийн нээлтийн арга хэмжээг, багуудын нэгдсэн өдөрлөгийг 2019.01.15,16-ний өдрүүдэд зохион байгуулж ИТХ-ын дарга Н.Буянхишиг сум орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт, ажил арга хэмжээний талаар танилцууллаа. Мөн Засаг дарга орлогч Ж.Баяр-Эрдэнэ 2019 онд улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын талаар , ЗДТГ-ын мэргэжилтэн Д.Одгэрэл Хөдөө аж ахуйн талаар, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны дарга



Б.Булгамаа сумын Улаан Загалмайн Анхан Шатны Хорооны 2018 оны ажлын тайлан, Таны дэм-бусдад инээмсэглэл аяны тайлан, татварын төвлөрүүлэлт, зарцуулалтын талаар, Малын эмч Билгүүн,



Н.Туяамаа нар мал эмнэлэгийн үйл ажиллагаа, 2019 онд хийх ажлын төлөвлөгөөний талаар, ЗДТГ-ын дарга Б.Баярсайхан Цэргийн бүртгэл, Нотариат буюу тэмдэгтийн хураамж, Онцгой байдлын талаар, ЕБС-ийн Насан туршийн боловсролын нэгжийн багш Р.Баттогтох Сургуулийн үйл ажиллагааны талаар, Говийн бага



дархан цаазат газрын дарга Ч.Батсүх байгууллагынхаа үйл ажиллагааны талаар болон байгаль хамгаалах чиглэлийн судалгааны талаар тус тус мэдээлэл хийж, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Нэргүй цаг үеийн мэдээлэл, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж зааврыг өгч ажиллаа.

- Төрөөс баримталж буй Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр, шийдвэр, уламжлалт мал маллагааны арга ухааныг сурталчилан таниулах, малчдын нийгмийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, малчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Малчдын зөвлөгөөн-2019" арга хэмжээг 2019.03.03-04-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнөөр Байгальд ээлтэй ноолуур төсөл, Байгаль зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэгтэй хамтран байгальд ээлтэй ноолуур төслийн талаар, Номгон суманд бэлчээрийн

менежментийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлын талаар, малчид хөдөлмөрөө хоршиж ажиллах нь ямар ашигтай вэ зэрэг чиглэлээр сургалт мэдээллийг өгч, мал аж ахуй, үйлдвэржилтийн цаагдын зорилтын талаар хэлэлцүүлэг хийж, уриалга гарган ажиллаа.

- Мөн багуудын малчин залуучуудын дунд Гар бөмбөг, цэнгээнт бүжгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.

Номгон сумын ИТХ, Улаан Загалмайн Анхан Шатны Хорооноос УЗАШХ-нд бүртгэлтэй гишүүд, ивээн тэтгэгч, онцгой гишүүдээ алдаршуулах, сумын анхан шатны хорооны үйл ажилллагааг идэвхижүүлэхэд оруулж буй тэдний хувь нэмрийг нийтэд таниулах, онцгой гишүүдийнхээ эгнээг өргөжүүлэх зорилгоор .аймгийн УЗДШХороотой хамтран "МУЗН-ийн гишүүдийн оролцоо" арга хэмжээг 2019.03.03-ний өдөр зохион байгуулж нийт 40 гаруй гишүүд, дэмжигчдийг хамруулж мэдээлэл хийж, гишүүн шинээр элсүүлэн, гарын авлага материал түгээж ажиллаа.



- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Номгон сумын “Дархан бэр” энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох журмын дагуу нийт 32 эхийг дархан бэрээр өргөмжлөн Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл, сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран тэднийг алдаршуулах, сумын 9 эрдэнийн өргөмжлөлт ээжүүдийг тодруулан хүндэтгэл үзүүлэх болон бусад олон арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.

- Сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын зөвлөгөөнийг 2019.04.04-ний өдөр зохион байгуулж төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар байгууллагуудын илтгэл, мэдээллийг сонсон, төрийн албан хаагчдад зориулсан сургалт мэдээллийг хийж нийт 40 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа. ИТХ-ын Ажлын албанаас Төрийн албаны тухай хууль, төрийн албаны шатлан дэвших зарчим, аймгийн Насан туршийн боловсролын төвөөс төрийн албан хаагчдын ёс зүй, төрийн албан хаагчдын харилцаа, хандлага сэдвээр сургалт хийлээ. Мөн төрийн албан хаагчдын дунд “Иргэдийн боловсрол ба иргэн төвтэй төрийн



үйлчилгээ” сэдэвт Дэвжээ тэмцээнийг зохион байгуулж байр эзлүүлэн шагнаж урамшууллаа.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арг хэмжээний шинэчилсэн маягтаар санал авах, хүн ам орон сууцны урьдчилсан бүртгэл судалгаа хийх, аймгийн ИТХ-аас малчид иргэдэд хүргэж байгаа ном, сумын ЗДТГ-аас бэлтгэсэн мэдээллийн



хуудас тараах, сум орон нутгийн цаг үеийн мэдээлэл өгөх, иргэдийн саналыг сонсох зэрэг ажлаар ИТХ-ын дарга Хармагтай багт, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Дэрсэнэ-ус багийн ажлын хэсэгт тус тус оролцож хөдөөгийн айл өрхөд хүрч ажиллаа.

- Улаан загалмайн хүмүүнлэгийн өдөр 05 дугаар сарын 08-ны өдөр Номгон сумын эрдэмтэн Р. Цэрэндоржийн нэрэмжит ЕБС-ийн Өсвөрийн Улаан Загалмайн бүлгийн багш, сурагчидтай хамтран МУЗН ийн үйл ажиллагаа, гишүүнчлэлийн талаар сурагчдад танилцуулга сургалт хийж, Өсвөрийн Улаан Загалмайн гишүүнээр элсэж байгаа хүүхдүүдийг бүртгэж үнэмлэх олгон тангараг өргүүллээ.





- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар аймаг, сум орон нутагт болж байгаа цаг үеийн мэдээлэл, Номгон сумын иргэдийн амжилт бүтээл, иргэдэд хүргэх зар мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. Үүнд: Хөрөнгө орлогын мэдүүлгээ хэрхэн гаргах вэ, Аймгийн 9 алдартан шалгаруулах журам, Алдарт эхийн одонгийн материал бүрдүүлэхэд юуг анхаарах вэ, 2018 оны жилийн эцсийн статистик мэдээ, Төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн тухай, Одон медалиа гээгдүүлсэн тохиолдолд нөхөн олгох журам зэрэг мэдээллийг цахимаар хүргэжээ.

- Сумын Соёлын төвийн хамт олныг Соёлын ажилтаны урлагийн анхдугаар наадамд оролцоход дэмжлэг үзүүлж нутгийн зон олонд сурталчилан ажилласан.



- Сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжин ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөрийг боловсруулан гаргаж, ахмадуудыг сумын бүтээн байгуулалттай танилцуулан тэдний санал бодлыг сонсох уулзалтын арга хэмжээ, ахмадуудын дундах уралдаан тэмцээнийг зохион байгуулж нийт 100 гаруй хүнийг хамруулсан.



Номгон суманд зохион байгуулагдсан цэргийн бүртгэлийн арга хэмжээний үеэр сумын ИТХ, ГХУСАЗСЗ-өөс цэргийн насны залуучуудад зориулан гэмт хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, архи согтууруулах ундааны хор уршиг, санхүүгийн боловсрол олгох чиглэлээр хуримтлалыг хэрхэн бий болгох вэ, түүний ашиг тус сэдвээр сургалтыг зохион байгуулж нийи 40 гаруй цэргийн насны залуучуудыг хамруулсан.



Сумын хэмжээнд “Соёлтой хэрэглэгч” аяны арга хэмжээг зохион байгуулж

- Хүүхэд хэрэглэгч "Хүүхдээ сонсоё" Хүүхдийн чуулганыг зохион байгуулж ЕБС-ийн 5-9 дүгээр ангийн нийт 130 гаруй хүүхдийг хамруулж санал бодол, илтгэлийг сонслоо.
- Чуулганы үеэр сумын ИТХ, Засаг даргаас хүүхдийн талаар хийсэн ажлаа тайлагнаж, Өмнөговь аймгийн ГБХЗХГ-аас "Манлайлалт" сургалтыг хийж, хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, гаргасан санал, хүсэлтийг нэгтгэн тус чуулганаас цаашид дараахь ажил, арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:
- Сумын хэмжээнд хүүхдийн спортын наадмыг зохион байгуулах
- "Хүүхэд хэрэглэгч" боловсрол олгох сургалтыг зохион байгуулах
- ЕБС-ийн авъяаслаг, бүтээлч багш чадвар, нөөц боломжид тулгуурлан хүүхдийн сонирхол, авъяасыг хөгжүүлэх чиглэлээр дугуйлан хичээллүүлэх, дугуйлангийн тоог нэмэгдүүлэх
- Спортын мастер Ц.Баярмаагийн "Гар бөмбөг"-ийн секц хичээллүүлэх
- Сумын төвийн гудамж, олон нийтийн газар хогийн сав байрлуулах
- Худалдаа үйлчилгээний газарт хяналт тавих ажлыг тогмолжуулах
- Золбин нохой устгах ажлыг жилд 2 удаа зохион байгуулах
- Хүүхдийг шүдний эмчийн үзлэгт жилд 2-3 удаа хамруулах
- Гитар хөгжмийн дугуйланд гитар хөгжмийн тоог нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг 2020 онд хэрэгжүүлэхээр хүүхдийн чуулганаас саналыг гаргаж баталлаа.

Үүний дагуу дээрх ажил арга хэмжээний саналыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг Засаг дарга болон холбогдох байгууллага албан тушаалтанд сумын ИТХ-аас албан тоотоор хүргүүлсэн болно.

- Мөн тус чуулганаар зарим тэргүүний сурагчдыг шагнаж урамшуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.



ЕБС-ийн сурагчдад Номгон сумын танилцуулга хийж, орон нутгийг судлах музейг үзүүлж сумын бүтээн байгуулалт болон зарим албан байгууллагатай танилцуулах ажлыг зохион байгуулж тус арга хэмжээнд ЕБС-ийн Х.Байгальмаа багштай 5-р ангийн 28 хүүхэд хамрууллаа. Сумынхаа түүх, бүтээн байгуулалттай танилцаж бяцхан ном хийх уралдаанд оролцож тэргүүлсэн сурагчдыг сумын Хурлаас шагнаж урамшууллаа.



Номгон сумын ЕБС- ийн Өсвөрийн Улаан Загалмайн бүлгийн 40 гаруй хүүхдүүдтэй хамтран хүмүүнлэгийн ажилд нэгдэж сумын төвөөс Төхөм, Хармагтай, аймаг руу гардаг зам дагуу болон хийморийн овоо, наадмын талбай зэрэг газруудын ойр орчимд бутраасан архи, пивоны шил савыг түүж ачуулан томчуудад хандан ТОМЧУУД АА! Уусан архиныхаа шилийг хаана хамаагүй хаяхгүй, хагалахгүй, соёлтой амьдарцгаая!!!!!! Уриалгыг хурлын цахим хуудсаар олон нийтэд сурталчилан таниуллаа.



- Сумын ИТХ-аас Татварын Улсын байцаагч Х.Мөнхбаттай хамтран "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хууль, "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" / ААНОАТТ/ хуулийн сургалтыг хийж нийт ААН, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 14 хүнийг хамрууллаа.
- Сумын ИТХ-аас Бизнес эрхлэгчидтэй ярилцаж санал бодлыг сонсож цаашид дэлгүүрүүд гадна орчин, талбайгаа тохижуулах, гэрэлтүүлэг хийх, соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх, хүмүүнлэгийн үйлсэд нэгдэх, нийгмийн хариуцлагаа дээшлүүлэх, харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллахаар болж дэлгүүр, ААН –ийн дунд болзолт уралдааныш зарлан 12 сард багтаан дүгнэж эхний 3 байрыг шалгаруулан сумын Хурлын өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.
- Сургалт, арга хэмжээний үеэр бизнес эрхлэгчдийн чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, тэдэнд эрч хүч, урам хайрлах зорилгоор хөгжилтэй тэмцээн уралдаан явуулж азтанг тодрууллаа.



Хуучин ЗДТГ-ын байранд үйл ажиллагаа явуулж байгаа болон амьдарч буй хүсүүсийн байдалтай газар дээр нь очиж танилцан тэнд амьдарч байгаа хүмүүсийн төлөөлөл, цэргийн анги, барилгын компануудын удирдлага, холбогдох албаны хүмүүстэй уулзаж тус барилгын эзэмшилт, тохижилт, гэрээ, түрээсийн төлбөрийн талаар тодруулан өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар холбогдох хүмүүст үүрэг чиглэл, зөвлөмжийг өгч ажиллаа.



Өмнөговь аймагт зохион байгуулагдах Англи хэлний баяр, олимпиадад оролцсон сумын ЕБС-ийн Өсвөрийн Улаан Загалмайн бүлгийн сурагчдыг аймгийн УЗДШХ-ны үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгууллаа.



Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор зохион байгуулагдсан шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах "Шатар"-ын тэмцээнийг зохион байгуулсанаас эрэгтэйчүүдээс хувиараа хөдөлмөр эрхлэгч А.Баттулга 1-р, Хармагтай



багийн малчин Г.Бат-Эрдэнэ 2-р, Насан туршийн боловсролын багш Р.Баттогтох 3-р байрыг тус тус эзэллээ.

Эмэгтэйчүүдээс Эрүүл мэндийн төвийн их эмч Х.Содбаяр тэргүүлж, ЗДТГ-ын даргыг орлон гүйцэтгэгч, нийгмийн ажилтан Ц.Баярмаа, Анагаах ухааны дээд сургуулийн оюутан С.Оюун-Эрдэнэ, ХААН банкны эрхлэгч Г.Цэндоо нар амжилттай оролцлоо.



Шатрын тэмцээнд тэргүүлсэн тамирчдад УИХ-

ын гарын үзэг бүхий аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох батламжийг, сумын ИТХ-ын Өргөмжлөл, мөнгөн шагналыг гардуулан өгсөн.

- Сумын ИТХ-аас Төрийн архивт 1992 оноос 2015 оны сум багийн хурлын хуралдааны материал, Тэргүүлэгчдийн хурлын материал, Хурлын даргын захирамж зэрэг 70 ширхэг баримтыг стандартын дагуу архивлаж хүлээлгэн өглөө.

- Хармагтай, Төхөм, Дэрсэнэ –ус, Эмгэнбулаг, Богт багуудын ойн арга хэмжээ, үйл ажиллагаанд баг тус бүрт 200,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж сумын Хурлын дарга, багаас сонгогдсон хурлын төлөөлөгчид ойн арга хэмжээнд оролцож үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаа.

МУЗН-ийн үйл ажиллагааг дэмжин , дунд шатны хорооноос өгсөн чиг, үүрэг, зөвлөмжийн дагуу МУЗН-ийн гишүүний эгнээг өргөтгөх, хүмүүнлэг ажил, арга хэмжээг зохион байгуулах, татвар хандивыг төвлөрүүлэх зэргээр сумын анхан шатны хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа иргэдэд сурталчлан ажиллаж 2019 оны ажлын тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлэн 2019 онд нийт 3,648,0 төгрөгийн татварыг төвлөрүүлэн, МУЗН-ийн онцгой гишүүнээр тус онд нийт 20 хүнийг шинээр элсүүлж ажлаараа дэд байранд шалгарсан амжилттай ажиллаа.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
December 25, 2019 at 10:51 AM

ХҮМҮҮНЛЭГ НОМГОНЧУУД:
2019 онд МУЗН-ийн Онцгой гишүүнээр Төхөм багийн залуу малчин Ө.Магсаржав, М.Анхцэцэг нарын гэр бүл, Эмгэнбулаг багийн малчин залуу С.Мөнх-Эрдэнэ, Ц.Мөнбаяр нарын гэр бүл, Хармагтай багийн малчин Ц.Эрдэнэбат, Б.Нэрвий нарын гэр бүл, Э.Батчулуун, Н.Бямбаа нарын гэр бүл, Богт багийн малчин Б.Отгондүү, Б.Дэлгэрмаа нарын гэр бүл, Хармагтай багийн малчин Н.Ундрахбаяр, оюутан Б.Насанцэцэг, Богт багийн иргэн Б.Баттүвшин, Хармагай багийн малчин Э.Тогтуунбаяр, Төхөм багийн малын эмч А.Эрдэнэзаяа, Засаг дарга асан Ц.Буяндэлгэр, Ж.Баяр-Эрдэнэ, ЗДТГ байгаль хамгаалагч С.Амаржаргал, Эмгэнбулаг багийн малчин Ө.Болдсайхан, Хармагтай багийн малчин Г.Хоролгарав нарын 20 хүн шинээр элсэж МУЗН-ийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж байна.

Сумын ИТХ, УЗХШХороо



Шинэ жилийн баярын арга хэмжээг архигүй тэмдэглэн өнгөрүүлэх уриалга гарган сумын Соёл спортын цогцолбор ашиглалтад орж байгаатай холбогдлууан Төрийн албан хаагчдын нэгдсэн шинэ жилийг анх удаа санаачлан зохион байгуулж төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байгууллагууд шилдэг тэргүүний төрийн албан хаагчдаа шагнаж урамшуулах, амжилт бүтээлийг сурталчлах, нэгнээсээ суралцах боломжийг ханган нийт 120 албан хаагчдыг хамрууллаа.



ХЯНАСАН:

ХУРДЫН ДАРГА

Н.БУЯНХИШИГ

ТАЙЛАН БИЧСЭН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БУЛГАМАА

ХЯНАСАН:

ХУРДЫН ДАРГА

Н.БУЯНХИШИГ

ТАЙЛАН БИЧСЭН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БУЛГАМАА